

**НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН 2016 ОНЫ ЗОРИЛТООС НАЛАЙХ ДҮҮРЭГТ  
(ХАМААРАЛТАЙ) ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ**

**2016 он**

<b>Д/д</b>	<b>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт</b>	<b>2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа</b>	<b>Хэрэгжүүлэх хугацаа</b>	<b>Хариуцах байгууллага</b>
<b>НЭГ. АГААР ЦЭВЭР УЛААНБААТАР</b>				
<b>1.1. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр</b>				
1	1.1.1 Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжууд, хиймэл нуур, цөөрөм, усан оргилууруудыг байгуулах замаар агаарын чийгшилтийг нэмэгдүүлнэ.	3 га газарт бичил цэцэрлэг байгуулна.	I-III улирал	ЗАА, Цэцэрлэгжүүлэлтийн алба
		Нийслэлийн нутаг дэвсгэрт байрлах хиймэл нуур, цөөрөм, усан оргилууруудын судалгааг гарган бүртгэлжүүлж, хэвийн үйл ажиллагааг хангах журам боловсруулна.	I-IV улирал	ЗАА, ӨГХА
2	1.1.5 Хотын тоосжилтыг бууруулах зорилгоор сул шороон хөрс бүхий гудамж, талбайг зүлэгжүүлэх эсхүл хатуу хучилттай болгох журам гаргаж мөрдүүлнэ.	Сул шороон хөрс бүхий 30 мянган м.кв талбайг зүлэгжүүлэн, эко хавтан, хатуу хучилттай болгоно.	II-III улирал	ЗАА, ЦА, Байгууллага, аж ахуйн нэгжүүд
3	1.1.7 Усан халаалтын болон технологийн зориулалт бүхий зуухнуудад бүртгэл хяналтын тогтолцоо нэвтрүүлж, технологийн шинэчлэл хийнэ.	2015 оны магадлан итгэмжлэлд хангалтгүй дүн үзүүлсэн болон шинээр баригдсан халаалтын зуухнуудыг хамруулан, хангалтгүй дүн үзүүлсэн газруудад сайжруулах, шинэчлэх, бусад холбогдох арга хэмжээг авч ажиллана.	I-IV улирал	ЗАА, ДС ТӨХК, Хороод
		Халаалтын зуухнаас ялгарах тоосонцрын хэмжээг багасгах талаар галч болон техникийн ажилтнуудад сургалт зохион байгуулна.	II-III улирал	ЗАА, ДС ТӨХК
<b>1.2 Хөрс болон орчны бохирдлыг бууруулах чиглэлээр:</b>				
4	1.2.1 Хотын нийтийн эзэмшлийн зам талбайн арчилгаа, цэвэрлэгээг тусгай зориулалтын техник, хэрэгслээр хийж гүйцэтгэнэ.	Нийтийн эзэмшлийн зам талбайн арчилгаа, цэвэрлэгээг тусгай зориулалтын техник, хэрэгслээр хийж, цэвэрлэгээний чанарыг сайжруулна.	I-IV улирал	ЗАА, Налайх-Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ
5	1.2.4 Улаанбаатар хотын аюултай хог хаягдлыг цуглуулан устгах менежментийн шинэ	Нийслэлийн хэмжээнд байгаа төвлөрсөн болон бие даасан инженерийн системд холбогдоогүй	I-IV улирал	ЗДТГ, ЗАА, 23, 123 -р цэцэрлэг,

	тогтолцоог бий болгоно.	сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийг сайжруулна.		Хувийн хэвшлийн цэцэрлэгүүд
	1.2.5 Зуслангийн болон шинэ суурьшлын бүсүүдэд хөрсийг бохирдлоос хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлж, бие даасан инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц бий болгох ажлыг эхлүүлнэ.	Зуслан, ногоон бүс, гэр хорооллын айл өрхийн бохирын цооногийг ариутган, хөрсийг халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулна.	II-III улирал	ЗАА, ЗДТГ, Хороод
<b>1.3 Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр:</b>				
6	1.3.2 Нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалтын тогтолцоог нийслэлийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын идэвх санаачлагад тулгуурлан бий болгон хөгжүүлнэ.	Газар эзэмшигч, ашиглагч иргэн, нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад 50м хүртэлх орчны нийтийн эдэлбэрийн газрын тохижилт, цэвэрлэгээ, арчилгааг хариуцуулж, нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалтын тогтолцоог сайжруулна.	I-IV улирал	ЗАА, Налайх Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ, Цэцэрлэгжүүлэлтийн алба, Хороод
		ЕБС-ын дэргэд “Эко клуб” байгуулах ажлыг ргэлжлүүлэн зохион байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулж, орчноо цэцэрлэгжүүлэх чиглэлээр заавар зөвлөмж өгч ажиллана.	I-IV улирал	ЗАА, Цэцэрлэгжүүлэлтийн алба
		“Шарилжгүй Улаанбаатар” хөдөлгөөнийг иргэдийн оролцоотой өрнүүлж, харшил үүсгэгч хог ургамлыг устгах орчин үеийн химийн аргын тусламжтайгаар нийслэлийн нутаг дэвсгэр дэх хог ургамлыг бүрэн устгах	II-III улирал	ЗАА, ЗДТГ, ЭМТ, ӨЭМТ, Хороод
7	1.3.3 Эзэмшлийн талбайн тохижилт, ногоон байгууламжийг өөрийн хөрөнгөөр байгуулж, арчлан хамгаалж буй аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах тогтолцоог бий болгоно.	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайг тохижуулсан байгууллага болон хашаандаа мод, сөөг тарьсан айл өрхийг урамшуулна.	II-III улирал	ЗАА, Налайх-Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ, Цэцэрлэгжүүлэлтийн алба, Хороод
		Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллана.	I-IV улирал	ЗАА, ЗДТГ
8	1.3.4 Төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж хотын ногоон бүсийг 20 хувь хүртэл нэмэгдүүлэн “Хотын эко цагдаа” ажиллуулна.	Усны эхийг хамгаалах зорилгоор ойжуулалтын ажлыг 300.0 га талбайд гүйцэтгэнэ.	I-IV улирал	ЗАА, ЦА

9	1.3.6 Нийслэлийн зуслангийн бүсийн байгаль орчныг хамгаалах, энэ бүсэд дахин төлөвлөлт хийх замаар ая тухтай, цэвэр агаар бүхий ногоон суурьшлын бүс болгон хөгжүүлнэ.	Нийслэлийн ногоон бүсэд зуслангийн нэр, чиглэл, анхааруулга, санамж бүхий мэдээллийн байгууламж байгуулна.	II-III улирал	ЗАА, Налайх-Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ
<b>1.4 Усны эх үүсвэрийг хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр:</b>				
10	1.4.1 Туул, Сэлбэ, Дунд голын усны урсацыг нэмэгдүүлэх, сэргээх, гадаргын усыг хуримтлуулах усан сан, цөөрөм байгуулж, хот орчмын голын ай сав газар, гол, булаг, шандыг хамгаалж, ногоон байгууламжийг байгуулна.	Нийслэлийн ногоон бүсэд 3 булгийн эхийг хамгаалж, 3 булгийн хамгаалалтын хашааг засварлана.	II-III улирал	ЗАА, Хороод
		Улаанбаатар хотын ундны усны эх үүсвэр Туул голын хамгаалалтын бүсийн дэглэмийн хэрэгжилтийг мөрдүүлж, авах арга хэмжээний санал боловсруулна.	I-IV улирал	ЗАА, Чандмань Налайх ОНӨААТҮГ
11	1.4.2 Хот орчмын түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахыг хязгаарлаж, байгалийн нөхөн сэргээлт хийнэ.	30 га талбайд нөхөн сэргээлт хийлгүүлнэ.	I-IV улирал	ЗАА
<b>ХОЁР. АМИНЫ СУУЦТАЙ УЛААНБААТАР</b>				
<b>2.1. Хот төлөвлөлт, газрын харилцааг нээлттэй, ил тод болгох чиглэлээр:</b>				
12	2.1.2 Иргэдийн оролцоотойгоор газар зохион байгуулалт, төлөвлөлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, барилга, объект барихдаа тухайн нутаг дэвсгэрийн оршин суугчдын саналыг заавал авдаг журамд шилжинэ.	Газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулахад иргэдийн саналыг цахим хэлбэрээр авч төлөвлөгөөнд тусгуулна.	I-IV улирал	ӨГХА
		Гэр хорооллын газар өмчлөгч, эзэмшигч 12000 иргэнийг хамруулсан уулзалт, сургалт зохион байгуулж, 880 иргэдийн бүлэг бий болгон, 7 “Иргэдийн түр зөвлөл” байгуулна.	I-IV улирал	ЗДТГ, ЗАА, ӨГХА, Хороод
13	2.1.3 Нийслэлд газрын харилцааны шинэчлэлт хийж, нийслэлийн иргэдэд газар өмчлүүлэх асуудлыг шийдвэрлэн өмчилсөн газраа санхүүгийн эргэлтэд оруулах бодит боломжийг бүрдүүлнэ.	Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар шинээр өмчлүүлэхээр батлагдсан 52 байршилд цахим хэлбэрээр газар өмчлүүлэх ажлыг дуусгаж, шинээр батлагдсан 68 байршилд үргэлжлүүлнэ.	I-IV улирал	ӨГХА
		Нийслэлийн нутаг дэвсгэр дэх зуслангийн газруудын батлагдсан хаягийн зураг, төлөвлөлтийн төслийн баримт бичгийн дагуу эзэмшигч иргэдэд нь гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх ажлыг зохион байгуулна,	I-IV улирал	ӨГХА

<b>2.3. Орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр:</b>				
14	2.3.2 Ашиглалтын шаардлага хангахгүй болсон хуучин орон сууцны барилгуудын газрын эрхийг бүртгэлжүүлж, иргэдийнх нь оролцоотойгоор дахин төлөвлөлт хийж барилгажуулах ажлыг концессын гэрээгээр хийж гүйцэтгэнэ.	Ашиглалтын шаардлага хангахгүй хуучин орон сууцны барилгуудыг дахин төлөвлөлтөд хамруулан барилгажуулах ажлыг эрчимжүүлэ.	I-IV улирал	ЗАА, ЗДТГ, ӨГХА
15	2.3.4 Иргэдийг орон сууцны зээлд хамруулж орон сууцжуулах нөхцөлийг бүрдүүлэх “Орон сууцны дэд хөтөлбөр”-ийг боловсруулж хэрэгжүүлнэ.	"Нийслэлийн орон сууцны хөтөлбөр"-ийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	I-IV улирал	ЗДТГ, ЗАА
		Төрийн албан хаагчдыг орон сууцны зээлд хамруулж, орон сууцжуулах нөхцлийг бүрдүүлэх	I-IV улирал	ЗДТГ, ЗАА
<b>2.5. Дагуул хот, суурингууд, алслагдсан дүүргүүдийг хөгжүүлэх чиглэлээр:</b>				
16	2.5.1 Улаанбаатар хотын дагуул хот, тосгон, суурьшлын бүсүүдийг хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, инженерийн хангамжийн бие даасан эх үүсвэрээс хангагдсан, тохилог амины орон сууцны хотхон, хороолол болгох чиглэлээр хөгжүүлнэ.	Орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр шинэ суурьшлын бүсийн эхний ээлжийн 8 байршилд техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулна.	I-IV улирал	ЗДТГ, ЗАА, ӨГХА
		Дагуул хот тосгоны 7 хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажилд хяналт тавин батлуулна./Тэрэлж, Жаргалант, Рашаант, Гачуурт, 361-ийн гарам, Өлзийт, Хонхор/	I-IV улирал	ЗДТГ, ӨГХА, 6-р хороо
17	2.5.3 Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, хөгжлийн чиг хандлагатай уялдуулан Багануур, Багахангай, Налайх дүүргийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан, батлуулж, хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.	Алслагдсан 3 дүүргийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавина.	I-IV улирал	ЗДТГ, ЗАА, ӨГХА
<b>ГУРАВ. АЖИЛТАЙ, ОРЛОГОТой УЛААНБААТАР</b>				
<b>3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр:</b>				
18	3.1.1 Нийслэл, дүүргүүдийн хөдөлмөрийн биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэн байнгын, түр, цагийн ажлын байраар хангах, зөвлөгөө өгөх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ.	Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран 15 мянган ажлын байрыг шинээр бий болгож, 20 мянган иргэнийг байнгын, түр ажлын байраар хангана.	I-IV улирал	НХХ, ХХ, Хороод

		Бичил бизнесийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор нийслэлийн 9 дүүрэгт 24 хүртэл га газрыг бизнес эрхлэгчид ашиглах боломжийг бүрдүүлнэ.	I-IV Улирал	НХХ, ХХ
		"Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр"-ийн хүрээнд байгуулагдсан "Хадгаламж зээлийн хоршоо"-ны үйл ажиллагааг бэхжүүлж, иргэдийг чадавхжуулна.	I-IV Улирал	ХХ, Хороод
		Цэргийн жинхэнэ албанаас халагдсан дайчдад мэргэжлийн сургалт, ажил танилцуулах өдөрлөгийг дүүргийн холбогдох хэлтэс, ажил олгогч байгууллагуудтай хамтран зохион байгуулна.	I-IV Улирал	НХ, НХХ, ХХ
		"Гэрээт цэрэг-Ажлын байр"-ны хүрээнд Цэргийн жинхэнэ алба хаасан залуучуудыг ЗХЖШ, ХХЕГ-т гэрээт цэрэг элсүүлж, ажлын байраар хангана.	I-IV Улирал	ЗДТГ, ЦШ
19	3.1.2. Шаардлагатай ажил мэргэжлийн жагсаалтыг хэрэгцээний дарааллаар гарган ажил, мэргэжилгүй 50000-аас доошгүй иргэдийг мэргэжил олгох болон мэргэшүүлэх давтан сургалтанд хамруулан тэдгээрийн 60-аас доошгүй хувийг байнгын ажлын байраар хангана.	Ажил, мэргэжилгүй 12 мянга хүртэлх иргэнийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн болон давтан сургалтад хамруулж, 60-аас доошгүй хувийг нь ажлын байраар хангана.	I-IV Улирал	НХХ, ХХ
		Хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй байгаа мэргэжил болон иргэдийн мэргэжлийн сургалтад хамрагдах эрэлт хэрэгцээг тодорхойлох судалгаа хийнэ.	I-IV Улирал	НХХ, ХХ, Хороод
20	3.1.3. "УБ агро парк"-ийн 100 га талбайг нийслэлийн ажилгүй иргэдэд хуваарилан, туслах аж ахуй эрхлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.	Төмс, хүнсний ногоо тариалах хүсэлтэй ажилгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин хүнсний ногоо тариалах боломжийг нэмэгдүүлнэ.	I-IV Улирал	НХХ, ХХ
21	3.1.4. Ахмад насны болон нийгмийн эмзэг бүлгийн иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эхчүүдэд амьдрах орчноо сайжруулах, байгаль орчноо нөхөн сэргээх ногоон ажлын байр бий болгох, хамтарч ажиллах боломжийг бүрдүүлнэ.	Тэнэмэл, орон гэргүй иргэдийн амьдрах нөхцлийг сайжруулах, нийгэмшүүлэх ажлыг төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	НХХ, ХХ	НХХ, ХХ
		Нийтийн эзэмшлийн гудамж, талбайг арчлах, хамгаалах, амьдрах орчноо сайжруулахад	I-IV Улирал	НХХ, ХХ

		чиглэсэн санал санаачилгыг дэмжин 1500 хүртэлх иргэнийг түр ажлын байраар хангана.		
22	3.1.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах, хөгжүүлэх төвийг дүүрэг бүрт байгуулна.	Нийслэлийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тооллого, судалгаа гарган мэдээллийн сантай болно.	I-IV Улирал	НХХ, НХҮХ, СБХ, Хороод
		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах хөгжүүлэх төвийн барилгын газрын байршлыг тогтооно.	I-IV улирал	НХХ, НХҮХ, ХГХТ, ӨГХА
<b>3.2. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр:</b>				
23	3.2.1. Зээлийн барьцаа, баталгааны механизмыг хөнгөвчилж, батлан даалтын хуулийг хэрэгжүүлэн нийслэлийн ЖДҮ-ийн төвийн үйл ажиллагааг идэвхижүүлнэ.	Нийслэлийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаар дамжуулан жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүжилт олгох боломжийг нэмэгдүүлнэ.	I-IV улирал	ЗАА, ЖДҮДТ
24	3.2.2. Аж ахуйн ур чадвар эзэмшүүлэх сургалт, бизнес инкубаци болон төсөл хөтөлбөр боловсруулах зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээний дэмжлэг үзүүлнэ.	Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд төсөл боловсруулах, үйлдвэрлэл, үйл ажиллагааны менежмент болон захиалгат сургалт зохион байгуулна.	I-IV улирал	ЗАА, ЖДҮДТ
		Жижиг, дунд, өрхийн үйлдвэр эрхлэгчдэд аж ахуйн ур чадвар эзэмшүүлэх, чадавхжуулах сургалтыг Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа томоохон үйлдвэрүүд дээр явуулна.	I-IV улирал	ЗАА, ЖДҮДТ
<b>3.3. Сургууль, цэцэрлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр:</b>				
25	3.3.1 Улсын болон хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих замаар Ерөнхий боловсролын сургуулийн, түүний дотор бага сургуулийн тоог эрс нэмэгдүүлэн хичээллэх ээлжийн тоог бууруулж, анги дүүргэлтийн стандартыг мөрдүүлнэ.	ЕБС-ийн багш нарын үйл ажиллагааг индексээр үнэлж, ажлын чанар, үр дүнг сайжруулна.	I-IV улирал	НХХ, БХ, ЕБС
26	3.3.2 Албан байгууллагуудын дэргэд болон гэр цэцэрлэг байгуулахыг дэмжинэ.	Иргэд, аж ахуйн нэгжүүдээс хүүхэд харах үйлчилгээ, алслагдсан гэр хороололд цэцэрлэгийн салбар бүлэг байгуулахыг дэмжинэ.	I-IV улирал	НХХ, БХ
<b>3.4. Аялал жуулчлалын хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр:</b>				
27	3.4.1. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг олшруулахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлнэ.	"Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	I-IV улирал	ЗАА, ЗДТГ, Байгууллагууд

<b>3.7. Налайх дүүргийг хөгжүүлэх чиглэлээр:</b>				
28	3.7.1 Орон нутгийн нүүрс, барилгын материалын түүхий эдийн нөөцийг түшиглэн бүх төрлийн барилгын материал, утаагүй түлшний үйлдвэрүүдийг цогцолбороор байгуулна.	Налайх дүүргийн Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн ажлын зураг төсвийг хийлгэнэ.	I-IV улирал	ЗДТГ, ЗАА
		Налайх дүүргийн Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн цахилгаан, усан хангамжийн системийн бүтээн байгуулалтын ажлыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулна.	I-IV улирал	ЗДТГ, ЗАА
<b>3.8. Эрчимжсэн аж ахуйн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх:</b>				
29	3.8.1. Улаанбаатар хотын сүүний хэрэглээний 80 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангана.	Сонгинохайрхан, Налайх дүүрэгт “Малын худалдааны төв” ОНӨТҮГ байгуулах ажлыг судална.	I-IV улирал	ЗАА, ЗДТГ
30	3.8.2. Нийслэлийн Сонгино, Бөхөгийн орчмыг гахай, шувуу, загасны аж ахуй эрхлэх бүс болгон хөгжүүлнэ.	Шувууны аж ахуй эрхлэгчдэд эрүүл ахуйн журмын хэрэгжилтийг мөрдүүлж, зөрчлийг арилгуулж, эрсдлийг бууруулах арга хэмжээ авч ажиллана.	I-IV улирал	НМХГ-ын Налайх дахь МХХ
31	3.8.3. Нийслэлийн иргэдийн төмс, хүнсний ногооны хэрэгцээг бүрэн хангана	“Алтан намар” үзэсгэлэн худалдаа зохион байгуулна.	I-IV улирал	ЗАА, Хороод
		Төмс, хүнсний ногооны тариалан эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжид хүнсний ногоо, жимс, жимсгэнийг тариалах технологийг зааж сургах, үр суулгац үржүүлэх, шинэ таримлыг нутагшуулах, шинэ техник, технологийг нэвтрүүлэх талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч дэмжин ажиллана.	I-IV улирал	ЗАА, ЦА
		Иргэдийг эрүүл, аюулгүй, шинэ ургацын ногоо, жимс, жимсгэнээр хангахын тулд хүлэмж, газар тариалан эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн ургамал хамгаалал, химийн бодис, бордооны хэрэглээг бууруулах, органик бүтээгдхүүн үйлдвэрлэхэд хяналт тавьж, зөвлөмж өгнө.	I-IV улирал	НМХГ-ын Налайх дахь МХХ, ЗАА
<b>3.10. Нийслэлийн санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх чиглэлээр:</b>				
32	3.10.2 Нийслэлийн иргэдийн ажиллаж амьдрах эрүүл, тохилог, аюулгүй орчинг бүрдүүлэх	Орон нутгийн хөгжлийн сангийн үр өгөөж, ашиглалтыг сайжруулна.	I улирал	СТСХ

	зорилгоор “Орон нутгийн хөгжлийг дэмжих” санг байгуулж, иргэд, олон нийтийн оролцоотойгоор төлөвлөж, зарцуулна.			
33	3.10.1 Нийслэл хотын албан татварын тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүдийг шинэчлэн боловсруулж, хууль санаачлах эрх бүхий этгээдэд өргөн барина.	Нийслэл хотын албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулж, татварын орлогын бүрдүүлэлтийг ханган ажиллана.	I-IV улирал	Татварын хэлтэс
34	3.10.3 “Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай” хуулинд заагдсан хязгаарын хүрээнд татварын хувь хэмжээг нийслэлийн хэмжээнд бүсчилсэн байдлаар шинэчлэн тогтоож мөрдүүлнэ.	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь хэмжээг газрын үнэлгээний бүсчлэлтэй уялдуулан шаталсан байдлаар шинэчлэн тогтоосны дагуу хэрэгжилтийг ханган ажиллана.	I-IV улирал	Татварын хэлтэс
35	3.10.6 Иргэдэд зайлшгүй үйлчилгээ үзүүлэхээс бусад салбарын алдагдалтай ажиллаж буй нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох, үйл ажиллагааны менежментийг сайжруулан ашигтай ажиллуулна.	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын удирдлагын багийг чадваржуулан, контрактаар хүлээсэн үүрэг, бизнес төлөвлөгөөний биелэлттэй уялдуулан хариуцлагыг тухай бүр тооцдог тогтолцоог бий болгож, үйл ажиллагааг оновчтой зохион байгуулан эдийн засгийн үр дүнг дээшлүүлнэ.	I-IV улирал	ЗАА, СТСХ

#### **ДӨРӨВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАН УЛААНБААТАР**

##### **4.1. Хотын аюулгүй байдлыг ханган, хэв журмыг сахиулах чиглэлээр:**

36	4.1.1 Архи, тамхи үйлдвэрлэх, худалдан борлуулахад тавих хяналтыг чангатгаж, хэрэглээний соёлыг төлөвшүүлнэ.	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудад хяналт таьж, сургалт зохион байгуулна.	I-IV улирал	ЗАА, МХХ
		Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, архи, тамхины хэрэглээний соёлыг төлөвшүүлэх чиглэлээр зөвлөмж, сэрэмжлүүлэг, мэдээлэл бэлтгэн хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж олон нийтэд хүргэнэ.	I-IV улирал	ЗАА, МХХ, ЦХ
		“Тамхигүй Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	I-IV улирал	ЗАА, МХХ, ЦХ
37	4.1.2 Төсвийн мөнгөөр архи, согтууруулах ундаа худалдаж авахыг хориглоно.	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, нийслэлийн өмчит үйлдвэрийн газрууд төсвийн мөнгөөр архи, согтууруулах ундаа худалдан	I-IV улирал	ЗДТГ, ЗАА, Байгууллагууд



		авахыг зогсооно.		
38	4.1.3 Гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээнд гардаг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн идэвхи санаачлагад суурилсан "хөршийн хамгаалалт" амгалан тайван байдлын тогтолцоо бүрдүүлнэ.	"Хөршийн хяналт" хөтөлбөрийн үйл ажиллагааг хэвшүүлж, гэмт хэрэг, зөрчлийн гаралт буурсан эерэг үзүүлэлттэй тэргүүн туршлага болохуйц "Хөршийн хяналт холбоо"-ны ажлыг иргэд, олон нийтэд сурталчилна.	I-IV улирал	ЗАА, ЗХХ, Хороод, Цагдаагийн хэлтэс
		Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, үүнд хүүхэд өртөхөөс сэргийлэх, эрсдлээс шуурхай хамгаалах чиглэлээр мэдээлэл, сурталчилгааны ажлыг гүйцэтгэнэ	I-IV улирал	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төв, Хороод, Цагдаагийн хэлтэс
39	4.1.4 Хэв журам сахиулах, гэмт хэрэг ба захиргааны зөрчилтэй тэмцэх ажлыг хотын удирдлага шууд хариуцна.	Гудамж талбайд үйлдэгдэж буй гэмт хэргийн гаралтыг бууруулах чиглэлээр иргэдийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу урамшилт эргүүлээр ажиллуулж, үр дүнг тооцно.	I-IV улирал	Цагдаагийн хэлтэс
		Олон нийтийн цагдаагийн ажилтны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, техник тусгай хэрэгслээр ханган ажилтны тоог нэмэгдүүлнэ.	I улирал	Цагдаагийн хэлтэс
40	4.1.5 Мансууруулах бодисын хорт нөлөөг таниулан, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.	Биеийн тамир, спортоор дамжуулан хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, иргэдийн хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор нийтийг хамарсан биеийн тамир, чийрэгжүүлэлтийн арга хэмжээг нэмэгдүүлж, "Улаанбаатар марафон" бүх нийтийн гүйлтийг зохион байгуулна.	I-IV улирал	НХХ, Биеийн тамир, спортын хороо
		Мансууруулах бодисын хор хөнөөлийг олон нийтэд танилцуулах чиглэлээр сурталчилгааны багцыг боловсруулан хэвлүүлж, их дээд сургууль, ерөнхий боловсролын сургуулиудын оюутан, сурагчдад энэ талаарх мэдлэг олгох сургалт зохион байгуулна.	I-IV улирал	НХХ, Цагдаагийн хэлтэс, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төв,
		Хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээнд судалгаа хийж, хор хөнөөлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулна.	I-IV улирал	ЭМТ

41	4.1.6 Нийслэлийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, нийслэлийн цагдаагийн байгууллагыг шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангана	Нийслэлийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангана.	I-IV улирал	Цагдаагийн хэлтэс
<b>4.2. Иргэндээ ээлтэй эрүүл, аюулгүй, тохилог орчин бүрдүүлэх чиглэлээр:</b>				
42	4.2.1 Улаанбаатар хотод баригдах барилга угсралтын ажлын техникийн болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг чанд мөрдүүлж, хяналтын тогтолцоог шинэчлэх замаар иргэдийн аюулгүй байдлыг хангана.	Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авсан захиалагч, гүйцэтгэгч нарт барилга угсралтын ажлын техникийн болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг чанд мөрдүүлж ажиллах талаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.	I-IV улирал	ЗАА, Мэргэжлийн хяналтын хэлтэс
		Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах талаар салбарын болон автобустай сургалтуудыг зохион байгуулна.	I-IV улирал	Мэргэжлийн хяналтын хэлтэс
		Аюулгүй ажиллагааг хангаж ажиллах талаар санамж, сэрэмжлүүлэг, гарын авлага зэрэг сурталчилгааны материал бэлтгэж, аж ахуйн нэгж, иргэдэд хүргэнэ.	I-IV улирал	Мэргэжлийн хяналтын хэлтэс
43	4.2.2 Барилга байгууламж, гудамжинд нийтийн гарцтай, хүүхдийн тоглоомын ба иргэдийн амралтын талбай, ногоон байгууламжтай байх шаардлагыг хатуу мөрдүүлнэ.	Шинээр баригдах барилга байгууламжийн 30 хувьд нь ногоон байгууламж байх заалтыг хэрэгжүүлэх, зураг төсөлд болон орц, гарцын байдал зэрэгт хяналт тавин гүйцэтгүүлнэ.	I-IV улирал	Мэргэжлийн хяналтын хэлтэс
44	4.2.3 Нийтийн эзэмшлийн гудамж, талбай, явган зам, нийтийн үйлчилгээний газруудад гэрэлтүүлэг, аюулгүй байдлын хяналтын сүлжээ бий болгоно.	Нийтийн эзэмшлийн зам талбай, орон сууц, гэр хорооллын камер гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, гэрэлтүүлгийг алсаас хянах нэгдсэн удирдлагын системийг хэрэгжүүлнэ.	I-IV улирал	ЗАА
45	4.2.7 Тусгай зориулалтын зам, шат, хаалга, бие засах газрууд байгуулах ажлыг дэмжиж хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан үйлчилгээг нэмэгдүүлнэ.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийн стандартыг хангуулах чиглэлээр төрийн бус байгууллагатай хамтран ажиллана.	I-IV улирал	ЗАА, НХХ

46	4.2.8 Аж ахуйн нэгж, байгууллагад ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтны хөдөлмөрийн эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд мэргэжлийн хяналтыг сайжруулах, болзошгүй үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлнэ.	Үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	I-IV улирал	ЗАА, НХХ, ЭМТ
47	4.2.10 Нийслэлийн дүүргүүдэд усан сан бүхий спортын ордон барих ажлыг үргэлжлүүлж, дугуйн болон гүйлтийн зам, мөсөн гулгуурын талбай шинээр барьж хүн бүр биеийн тамир, спортоор хичээллэх, хот, суурин газар, байгууллага, хамт олон, өрх гэр бүлд эрүүл амьдралын орчин нөхцөлийг бүрдүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Олон нийтийг хамарсан спортын арга хэмжээг тодорхой хугацааны цагалбарт оруулах, мэргэжлийн спорт, холбоодын тэмцээн уралдааныг олон нийтэд хүргэх, мэдээлэх ажлыг зохион байгуулна.	I-IV улирал	НХХ, Биеийн тамир, спортын хороо
		Нийслэлийн болон дүүргийн спорт цогцолборын барилга угсралтын ажлыг эрчимжүүлнэ. /ЧД, БГД, БЗД, НД, СХД/	I-IV улирал	НХХ, Биеийн тамир, спортын хороо
48	4.2.13 Иргэдийг өвчлөлтөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлж, хороодын Өрхийн эрүүл мэндийн төвийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.	Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.	I-IV улирал	
		“Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд: 1. Ногоон бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа сувиллуудад хяналт тавьж, аялал жуулчлалд ээлтэй орчин бүрдүүлнэ. 2. Гадаадын жуулчдад гэмтэл осол, гэнэтийн өвчлөлийн үед түргэн тусламж үзүүлж, дараагийн шатны эмнэлэгт хүргэх ажлыг шуурхай зохион байгуулах талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.	I-IV улирал	НХХ, Эрүүл мэндийн төв
		ӨЭМТ-ийн эмч, мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж, ёс зүйн харилцаа, хандлагыг сайжруулна,	I-IV улирал	НХХ, Эрүүл мэндийн төв
<b>4.4. Гамшгаас хамгаалах чиглэлээр:</b>				
49	4.4.1. Иргэдийг байгалийн гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор гамшгийн үед байрлах, хоргодох цэгүүдийг тогтоож, онцгой байдлын алба саадгүй хүрч	Төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, эмнэлэг болон их дээд сургууль, олон нийтийн барилгад газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварын үнэлгээг хийж паспортжуулна.	I-IV улирал	Онцгой байдлын хэлтэс, ЭМТ, СТСХ

	ажиллах орчинг бий болгоно.	Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдад гамшгаас хамгаалах анхан болон гүнзгийрүүлсэн шатны сургалтыг зохион байгуулж, үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг ханган, шаардлагатай хувцас, хэрэглэл олгож, үйл ажиллагаанд оролцоно.	I-IV улирал	ЦШ
<b>ТАВ. АВЛИГАГҮЙ УЛААНБААТАР</b>				
50	5.3. Авлигын эсрэг нийслэлийн Олон нийтийн зөвлөл байгуулна.	"Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлнэ.	I-IV улирал	ЗХХ, Байгууллагууд
		Авлигын эсрэг нийслэлийн олон нийтийн зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, тэдний оролцоотойгоор нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ил тод, нээлттэй байдалд хяналт тавина.	I-IV улирал	ЗХХ, Байгууллагууд
51	5.4 Хотын үйл ажиллагааг ил тод байлган, гүйцэтгэлд нь хяналт тавих эрхийг иргэдэд олгохын зэрэгцээ хотын тулгамдаж буй асуудлаар иргэдийн дунд олон нийтийн санал асуулга явуулж, тэдний саналд үндэслэн шийдвэр гаргадаг болно.	Нийслэлийн 2017 оны төсвийн төслийг иргэд, олон нийтийн оролцоотойгоор хэлэлцүүлэх ажлыг нийслэлийн иргэний танхимд зохион байгуулна.	I-IV улирал	ЗДТГ
		Шилэн дансны тухай хуулийн дагуу нийслэл, дүүргийн төсөв, гүйцэтгэлийн мэдээ, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит газруудын төсвийн мэдээлэл, зарлагын гүйцэтгэлийг цахим хуудсанд байршуулна.	I-IV улирал	СТСХ
		Төрийн үйлчилгээний төвийг Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан дүүрэгт байгуулж, үйл ажиллагааг нь бэхжүүлнэ.	I-IV улирал	ЗХХ
		Эрүүл, аюулгүй байдлын индексийг тооцоход шаардлагатай мэдээллийг бүртгэх, цуглуулах, боловсруулах үйл явцад хяналт, үнэлгээ хийнэ.	I-IV улирал	НХХ, ЗХХ
52	5.5. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас иргэд, аж ахуйн нэгжүүдэд үзүүлдэг ажил, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, цахим засаглалыг хөгжүүлнэ.	"Ухаалаг Улаанбаатар" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	I-IV улирал	ЗДТГ, ЗАА, Байгууллагууд
		Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас иргэн, аж ахуйн нэгжид үзүүлж үйлчилгээ нэг бүрийн үйл ажиллагааг тодорхой болгож, нэг стандартад шилжүүлэн, төрийн үйлчилгээний стандарт багцыг үйл	I-IV улирал	ЗДТГ, Хороод

		ажиллагаандаа нэвтрүүлнэ..		
		Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас иргэн, аж ахуйн нэгжид үзүүлж байгаа төрийн үйлчилгээний нэгдсэн программ хангамжийг хөгжүүлж, үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.	I-IV улирал	ЗДТГ, Хороод
		Хорооны хүн ам, өрхийн бүртгэлийн иж бүрэн байдлыг хангаж, уг бүртгэлээр мэдээллийн онлайн сан байгуулж ашиглана,	I-IV улирал	ЗДТГ, БСХ, Хороод
		Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллагын ээлжит тооллогыг нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулна.	III-IV улирал	БСХ
		Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын орон зайн мэдээллийн нэгдсэн сан байгуулах ажлыг эхлүүлнэ.	I-IV улирал	ЗДТГ
		Дүүргүүдийн төрийн архивын бие даасан үйл ажиллагааг дэмжиж, архивын сан хөмрөгөөс байгууллага, иргэдэд нэг цэгийн цахим үйлчилгээ үзүүлнэ.	I-IV улирал	ЗДТГ
		Хорооноос үзүүлж буй улсын бүртгэлийн үйлчилгээнд дэвшилтэт техник, технологийг ашиглаж, цахим үнэмлэхийг хэрэглээнд нэвтрүүлнэ.	I-IV улирал	БСХ
53	5.6. Хотын стандартыг тогтоож, тусгай зөвшөөрлийн агуулгыг шинэчлэн, олгох зарчмыг нь хөнгөвчилнэ.	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас олгож буй зөвшөөрлийн тогтолцоог стандартчилалтай уялдуулан зөвшөөрлийг олгодог болгоно.	I-IV улирал	ЗАА
54	5.7. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэн өргөтгөж, төрийн зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.	Төрийн зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	I-IV улирал	ЗДТГ, ЗАА, Хороод Байгууллага
55	5.13 Тендерийн будлиан, авилга, хээл хахуулийг халах зорилгоор төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг 100 хувь онлайн хэлбэрт	Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, ил тод, нээлттэй, шударга зохион байгуулна.	I-IV улирал	ХААА

	шилжүүлж, иргэд, олон нийтийн хяналт дор ил тод явуулна.	“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн төсөлд болон холбогдох журмын төсөлд саналаа тусгана	I-IV улирал	ХААА
56	5.14 Газрын бирж байгуулах асуудлыг холбогдох төрийн төв байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.	Газрын цахим дуудлага худалдааны үйл ажиллагааг эхлүүлнэ.	I-IV улирал	ӨГХА
57	5.15 Нийслэлийн төр захиргааны үйл ажиллагаанд хууль дээдлэх ёсыг бодитой хэрэгжүүлж, төрийн албан хаагчдыг сонирхлын зөрчил, авилгад өртөхгүй байх, урьдчилан сэргийлэх эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл олгох журмыг боловсронгуй болгож, олон нийтэд ил тод болгоно.	I-IV улирал	ЗАА

**НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ЗАХИРГАА, ХУУЛИЙН ХЭЛТЭС**